



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, тээврийн осол зөрчлийг бууруулах зорилгоор Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нарийнсухайтын орд газраас БНХАУ-д нийлүүлэх нүүрсний тээвэрлэлтийг концессын гэрээгээр баригдсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 43.2 км хүнд даацын хатуу хучилттай замаар тээвэрлэхээр тогтоосугай.

2. Улс хоорондын нүүрс тээвэрлэлтийн чиглэлийг тогтоосонтой холбогдуулан "Авто замын чиглэлийг тогтоох тухай" Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 183 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Нарийнсухайтын уурхайгаас Улсын хил хүртэлх авто замыг тогтоосон "Нарийнсухайтын баруун уурхай – Шивээхүрэнгийн шалган нэвтрүүлэх боомт – Улсын хил" чиглэлийг хүчингүй болгосугай.

3. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Цогтбаатар/-т үүрэг болгосугай:

3.1. Тогтоосон чиглэлээр нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтад холбогдох дүрэм, журам, норм нормативыг хангуулж, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт зохицуулалтаар хангаж ажиллах;

3.2. Чиглэл хүчингүй болгосонтой холбогдуулан хуучин ашиглаж байсан шороон замын байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг уурхай эзэмшигч, тээвэрлэгч нараар гүйцэтгүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

3.3. Нарийнсухайтын орд газраас БНХАУ-д нийлүүлэх нүүрсийг концессын гэрээгээр баригдсан хүнд даацын хатуу хучилттай авто замаар тээвэрлэх болсонтой холбогдуулан авто зам ашигласны төлбөрийн хэмжээг "Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто зам Барих-Ашиглах-Шилжүүлэх концессын гэрээ"-ний 1.12-д заасны дагуу мөрдүүлэх;

3.4. Нүүрс тээвэрлэлтийн чиглэл болон хүчингүй болгосон замын чиглэлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, тухайн орон нутгийн холбогдох байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

3.5. Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн 43.2 км хүнд даацын хатуу хучилттай авто замын засвар арчлалтыг концессын гэрээний дагуу концесс эзэмшигч "Ар Ди Си Си" ХХК-аар хариуцуулан гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллах;

4 Авто замын тухай хуулийн 6.1.2, Авто тээврийн хуулийн 7.1.1-д заасан өөрийн эрх, үүргийн дагуу тушаалын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Өмнөговь аймгийн Засаг дарга /Б.Бадраа/, Гурвантэс сумын Засаг дарга /Г.Гангамаа/ нарт үүрэг болгосугай.

5 Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг эргэн танилцуулахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Бямбажав/-т даалгасугай.



Н.ТӨМӨРХҮҮ